

ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ

2015 оны 04 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар.....

Улаанбаатар
хот

Энэхүү Хөдөлмөрийн Гэрээ (цаашид Гэрээ гэх)-г, нэг талаас Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК (цаашид “Ажил олгогч” гэх), нөгөө талаас Монгол Улсын иргэн Эрдэнийн Ванчинхүү (цаашид “Санхүү, удирдлагын газрын дарга” гэх, Регистрийн дугаар: ОП67090736) нар Хөдөлмөрийн хуулийн 21 дүгээр зүйл, 23 дугаар зүйлийн 23.2.2 дахь заалт, 24 дүгээр зүйлийн дагуу харилцан тохиролцож байгуулав.

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ЗОРИЛГО БА ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэ Гэрээний зорилго нь Санхүү, удирдлагын газрын даргын компанид гүйцэтгэх ажил болон түүнтэй холбогдон үүсэх хөдөлмөрийн харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэ Гэрээнд заасан ажил үүрэгтэй холбогдох үүрэг даалгаврыг Санхүү, удирдлагын газрын даргатай харилцан тохиролцсон цалин хөлсөөр гэрээний хугацаа, нөхцөлийн дагуу хийж гүйцэтгэх болон Ажил олгогчоос гэрээний дагуу уг цалин хөлсийг Санхүү, удирдлагын газрын даргад төлөх нь энэхүү гэрээний гол зүйл болно.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ. АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. Ажил, албан тушаал: Санхүү, удирдлагын газрын дарга
- 2.2. Санхүү, удирдлагын газрын дарга нь “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захиралд ажлаа тайлагнана.
- 2.3. Санхүү, удирдлагын газрын дарга нь Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн дүрэм болон бусад хууль тогтоомжид заасан эрх, үүргийг хүлээнэ.
- 2.4. Санхүү, удирдлагын газрын даргын хөдөлмөрийн нөхцөл нь хөдөлмөрийн хэвийн нөхцөл байна.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ. ХУГАЦАА

- 3.1. Талуудын харилцан тохиролцсоны дагуу Санхүү, удирдлагын газрын дарга гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг тухай бүр нь үнэлж дүгнэнэ.
- 3.2. Энэхүү Гэрээ нь 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хоёр жилийн хугацаанд хүчинтэй байна.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. АЖЛЫН ЦАГ

- 4.1. Талууд өөрөөр тохиролцоогүй бол ажлын ердийн өдрийн цагийн үргэлжлэх хугацаа 8 цаг байна. Санхүү, удирдлагын газрын даргын ажлын нөхцөл байдлаас шалтгаалан талууд шаардлагатай тохиолдолд ажлын цагийн тусгайлсан хуваарийг мөрдөж болно. Энэ тохиолдолд хуваарийг энэ Гэрээнд хавсаргана.
- 4.2. Захиргаанаас албан ёсоор хүссэн, эсхүл ахлах албан тушаалтнаас даалгасан ажлын шаардлагын дагуу илүү цаг ажиллах шаардлагатай тохиолдолд дээр дурдсан ердийн өдрийн ажлын цагийг сунгаж илүү цагаар ажиллаж болно.

- 4.3. Илүү цагаар ажилласныг нөхөн амруулаагүй тохиолдолд Компанийн дотоод журмын хүрээнд ажилтанд нэмэгдэл урамшуулал олгох, эсхүл Хөдөлмөрийн хуульд заасны дагуу ердийн цагийн хөлсийг 1.5 дахин нэмэгдүүлж илүү цагийн хөлсийг бодож олгоно.

ТАВДУГААР ЗҮЙЛ. ЦАЛИН ХӨЛС

- 5.1. Санхүү, удирдлагын газрын даргын сарын нийт цалин (татвар, нийгмийн даатгалыг хуульд заасны дагуу суутган тооцохоос өмнө) төгрөг байна.
- 5.2. Ажил олгогч нь Санхүү, удирдлагын газрын даргын цалин хөлсийг сар бүрийн 1, 3 дахь долоо хоногийн ажлын сүүлийн өдөр, тухайн өдөр бүх нийтээр амрах баярын болон амралтын өдөр таарвал өмнөх өдөр нь түүний банкны дансанд шилжүүлнэ.

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. АЖИЛТНЫ ҮҮРЭГ, ЭРХ

- 6.1. Санхүү, удирдлагын газрын дарга нь дор дурдсан үүрэг хүлээнэ:
- 6.1.1. Өөрийн ажил, үүргийг гүйцэтгэхдээ Монгол Улсын хууль тогтоомж, Компанийн Засаглалын Кодекс болон компанийн дотоод дүрэм, журам (хөдөлмөрийн болон галын аюулгүй байдлыг оролцуулан)-ыг чанд сахих;
 - 6.1.2. Энэхүү гэрээнд заасан ажил үйлчилгээг зохих ёсоор, үнэнчээр, өөрийн хүч чадвараа дээд зэргээр дайчлан мэргэжлийн өндөр түвшинд Ажил олгогчтой тохиролцсон хүрээ, цаг хугацаанд багтаан гүйцэтгэх;
 - 6.1.3. Санаатай болон санамсаргүй эсэхээс үл хамааран өөрийн хайхрамжгүй үйлдэл, эс үйлдлийн улмаас компанид учруулсан хохирол, гэм хор, үр дагаврын төлөө бүрэн хариуцлага хүлээх;
 - 6.1.4. Гэрээний хугацаанд Ажил олгогчийн өмнө хүлээж байгаа үүрэг, хариуцлагатай ижил төсөөтэй буюу компанийн хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхүйц үүрэг хариуцлагыг гуравдагч этгээдийн өмнө хүлээх буюу гүйцэтгэхгүй байх;
 - 6.1.5. Энэхүү гэрээний хугацаанд энэ Гэрээнээс гадуур буюу Ажил олгогчид өрсөлдөөн бий болгох үйл ажиллагаа явуулахгүй байх;
 - 6.1.6. Санхүү, удирдлагын газрын дарга нь Гэрээний хугацаанд өөрийн ажил үүргийн дагуу буюу ажил үүрэгтэй холбоотой үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх явцад мэдсэн нууцын болон байгууллагын бүх мэдээлэл, түүнчлэн тэдгээртэй холбоотой Ажил олгогч, эсвэл түүний нэрийн өмнөөс боловсруулсан мэдээ, мэдээлэл, тоо баримтын нууцлалыг хадгална. (Нууцын болон байгууллагын мэдээлэлд Ажил олгогчоос нууц гэж тооцогдсон бизнестэй холбоотой бүх мэдээлэл, томъёолол, тооцоолол, зураглал, чулуулгийн дээж, загвар, программ, аргачлал, технологи, ажилбар, санхүүгийн тайлан, түүнтэй холбоотой тоо баримтууд, арилжааны нууц мэдээлэл, санамж бичиг, тэмдэглэл, ноу-хау зэрэг орно);
 - 6.1.7. Ажил олгогчоос гэрээний үүргээ биелүүлэхэд нь зориулан олгосон бүх баримт бичиг, материал, хөдөлмөрийн багаж зэмсэг болон бусад зүйлсийг гамтай хэрэглэж Гэрээний хугацаа дууссаны дараа даруй буцааж хүлээлгэн өгөх;
- 6.2. Санхүү, удирдлагын газрын дарга нь дараах эрх эдэлнэ:
- 6.2.1. Ажлын байранд зохих хууль тогтоомжид заасны дагуу хөдөлмөрийн болон аюулгүй байдал, эрүүл ахуйн зохих нөхцөлөөр хангахыг шаардах;
 - 6.2.2. Ажил үүргээ гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг мэдээллийг хянах, Ажил олгогчоос гаргуулахаар шаардах;
 - 6.2.3. Талуудаас үл хамаарах шалтгаанаар ажлын явц хойшлогдсон бол Гэрээг дүгнэхийг шаардах;

ДОЛООДУГААР ЗҮЙЛ. АЖИЛ ОЛГОГЧИЙН ҮҮРЭГ, ЭРХ

- 7.1 Ажил олгогч дараахь үүрэг хүлээнэ:
 - 7.1.1 Гэрээнд заасан хөдөлмөрийн хөлсийг төлөх;
 - 7.1.2 Ажилтныг ажил, үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай хөдөлмөрийн болон аюулгүй байдал, эрүүл ахуйн зохих нөхцөлөөр хангах;
 - 7.1.3 Гэрээний үндсэн нөхцөлийг харгалзан үзэж ажлын цаг, хуваарийн талаар тохиролцох бөгөөд Санхүү, удирдлагын газрын даргад хууль бус буюу биелэх боломжгүй үүрэг даалгавар өгөхгүй байх;
- 7.2 Ажил олгогч дараахь эрх эдэлнэ:
 - 7.2.1 Ажлын явцыг хугацаа харгалзахгүйгээр шалгах;
 - 7.2.2 Гэрээний дагуу ажил үүргийг цаг хугацаанд нь чанартай биелүүлэхийг, түүнчлэн компанийн дүрэм болон бусад дотоод журмыг сахин биелүүлэхийг шаардах;

НАЙМДУГААР ЗҮЙЛ. ХАРИУЦЛАГА

- 8.1. Талууд энэхүү Гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүдсэн үүргээ бүрэн хэмжээгээр хариуцна.
- 8.2. Хэрэв Гэрээний аль нэг тал үүргээ биелүүлэхэд давагдашгүй хүчин зүйл нөлөөлсөн гэдгийг баталсан, эсвэл үүргээ биелүүлэх талаар боломжтой буюу шаардлагатай бүх арга хэмжээг авснаа нотолсон бол дээрх хариуцлагаас чөлөөлөгдөж болно.
- 8.3. Энэхүү Гэрээг байгуулах нь ажилтны эрх зүйн чадвар, чадамжийг хязгаарласан аливаа зүйл байхгүй гэдгийг баталж байгаа явдал бөгөөд хэрэв Ажилтан энэ Гэрээг байгуулснаар хэн нэгэн гуравдагч этгээдийн эрх ашгийг хөндсөн бол тэрээр энэхүү зөрчлөөс үүсэх аливаа хариуцлагыг бүрэн хүлээнэ.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. ГЭРЭЭГ ДУУСГАВАР БОЛГОХ, ЦУЦЛАХ, СУНГАХ

- 9.1. Энэхүү Гэрээ нь Хөдөлмөрийн хуулийн 37 дугаар зүйлд заасан үндэслэлээр дуусгавар болно.
- 9.2. Ажил олгогчийн санаачлагаар дараах тохиолдолд Гэрээг цуцалж болно. Үүнд:
 - 9.2.1 Ажил олгогч татан буугдсан;
 - 9.2.2 Тухайн ажилтны гүйцэтгэж байсан ажлын орон тоог цомхтгосон, эсхүл Ажил олгогч ажилтныхаа тоог цөөрүүлсэн;
 - 9.2.3 Ажилтан мэргэжил, ур чадвар, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь тогтоогдсон;
 - 9.2.4 Ажилтан хөдөлмөрийн сахилгын зөрчлийг хоёр буюу түүнээс дээш удаа давтан гаргасан;
 - 9.2.5 Сонгууль, томилолтоор өөр орон тооны ажил, албан тушаалд ажиллах болсон;
 - 9.2.6 Мөнгө болон эд хөрөнгө хариуцсан ажилтан өөрийн буруутай үйлдэл, эс үйлдлийн улмаас Ажил олгогчийн итгэлийг алдсан нь тогтоогдсон;
 - 9.2.7 Ажилтан гэмт хэрэгт холбогдон яллагдагчаар татагдсан, эсвэл ёс суртахууны зөрчил гаргасан;
 - 9.2.8 Ажил олгогчийн удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг, даалгаврыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гүйцэтгээгүй, эсвэл гүйцэтгэхээс татгалзсан;
 - 9.2.9 Ажил олгогчийн бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох зөрчил гаргасан;
 - 9.2.10. Санхүү, удирдлагын газрын дарга гэрээгээр хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь гүйцэтгээгүй, эсвэл үүрэгт ажилдаа хайхрамжгүй хандах;

- 9.2.11. Ажлын цагаар буюу ажлын байранд, түүнчлэн энэхүү Гэрээнд хамаарах ажил, үүргээ гүйцэтгэж байх үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн;
- 9.3. Талууд гэрээний хугацаа дуусахаас 10 хоногийн өмнө Гэрээ сунгах, эсвэл дуусгавар болгох талаар нөгөө талдаа албан ёсоор бичгээр буюу амаар мэдэгдэл өгнө. Хэрэв гэрээг сунгах мэдэгдэл өгсөн, эсхүл компани гэрээг цуцлах, эсхүл сунгах талаар мэдэгдэл өгөөгүй тохиолдолд Гэрээг хоёр жилээр сунгагдсанд тооцно. Гэрээ сунгах тохиолдол бүрт энэхүү журмыг баримтлана.

АРАВДУГААР ЗҮЙЛ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 10.1. Энэхүү Гэрээтэй, түүнчлэн гэрээний үйлчлэлийн үед буюу түүнээс хойшхи харилцаатай холбоотой, эсвэл тэдгээрээс үүдэн гарсан Талуудын хоорондын аливаа маргаан, зөрчил, гомдлыг хэлэлцээрийн боломжит бүх хэлбэрийг ашиглан талууд нөхөрсгөөр харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Гэсэн хэдий ч, дээрх заалт нь Талуудаас маргааныг шүүхийн журмаар шийдвэрлүүлэх эрхийг үл хөндөнө.

АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. БУСАД

- 11.1. Энэхүү Гэрээнд Монгол Улсын Хөдөлмөрийн хууль, Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг баримтлана.
- 11.2. Хэрэв хуульд зохих өөрчлөлт орох болон гэрээ байгуулахад хүргэсэн үеийн нөхцөл байдалд үндсэн өөрчлөлт орсны улмаас Гэрээний аль нэг нөхцөл заалт нь хуульд харшилсан буюу хэрэгжүүлэх боломжгүй, эсвэл бүхэлдээ буюу хэсэгчлэн хүчингүй болсон бол талууд Гэрээг хуульд нийцүүлэн өөрчлөн шинэчилнэ. Ингэсэн нь гэрээний хуульд нийцэж буй хүчин төгөлдөр бусад нөхцөл, заалтад нөлөөлөхгүй бөгөөд Талууд тэдгээр заалтыг дагаж мөрдөнө.
- 11.3. Энэхүү Гэрээ нь хамарч байгаа асуудлаараа Талуудын хоорондох хөдөлмөрийн бүх л харилцааг тодорхойлж байгаа бөгөөд Гэрээг ийнхүү байгуулснаар өмнө нь бичгээр болон амаар тохиролцсон бүх ойлголт, тохиролцоог хүчингүйд тооцно.
- 11.4. Энэхүү Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.
- 11.5. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Гэрээнд гагцхүү бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 11.6. Энэхүү Гэрээг монгол хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн болно.

Энэхүү Гэрээг 2015 оны 04 сарын 01-ний өдөр Улаанбаатар хотноо байгуулав.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**“Хөдөө аж ахуйн давхар даатгал”ХК-ийн
Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч:**

Санхүү, удирдлагын газрын дарга:

Б.Даажамба

Эрдэнийн ВАНЧИНХҮҮ